

Төлөвлөгөөг баталсан:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ



Л.БЯМБАСҮРЭН

Төлөвлөгөө боловсруулсан:

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.АЛТАНТУЯА

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
<b>Зорилго 1.</b> Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
<b>Зорилт 1.2.</b> Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1.2.1	БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	-	Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
1.2.2	БГТ 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.	-	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	-	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
1.2.3	"Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Журмыг хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
1.2.4	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
1.2.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.	-	-Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо	Санхүүжүүлсэн мөнгөн дүн - 408,860,000 Хамрагдсан даатгуулагчийн тоо- 3486	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
1.2.6	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд	-	Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого	-	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого	II, IV улирал	Хэлтсийн дарга Д.Алтантуяа

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
	нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.		төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо		төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.		
<b>Зорилт 1.4. "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд:</b>							
1.4.1	Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.1.3, БГТ-1.4.3 Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-	Хүргүүлсэн саналын тоо	12, 07 дугаар тогтоолын төсөлд нийт 6 санал хүргүүлсэн.	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
1.4.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо -Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	2023 онд аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Сум дундын иргэний хэргийн шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудтай хамтран ажилласан. Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн - 6800000	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга Д.Алтантуяа, Мэргэжилтэн Ч.Мягмарсүрэн
<b>Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.</b>							
<b>Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ.</b>							
2.1.1	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2023 онд 44,8 %	2024 онд 60 хувиас дээш хамруулна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2023 онд 16 %	2024 онд 30-аас дээш хувь хамруулна		
Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь			2023 онд 78,8 хувь	2024 онд 80-аас дээш хувь хамруулна.			
-Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь		2023 онд 104%	2024 онд шимтгэл төлөлт 98 хувиас доошгүй байна.				
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	-	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, тайлан мэдээг нэгтгэн 4 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 4 удаа хүргүүлсэн байна.	I-IV улирал	Мэргэжилтэн Ч.Мягмарсүрэн
2.1.3	Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	-	-Өглөг, авлагын тоо хэмжээ -Тайлан	2023 онд 66 ЭМБ-ын 1,025,694,000 төгрөгийн өглөг, 2 ЭМБ-ын 8910345 төгрөгийн авлагын тайланг гаргаж, ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.	I-IV улирал	Мэргэжилтэн Ч.Мягмарсүрэн

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
2.1.4	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.		Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2023 оны биелэлтийн хувь 80	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90-ээс доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	I-IV улирал	Хэлтсийн дарг Д.Алтантуяа, Ч.Мягмарсүрэн
<b>Зорилго 3:</b> Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна.							
<b>Зорилт 3.1.</b> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.							
3.1.1	БСТ-3.1.2, БГТ-3.1.1 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, сум, өрхийн эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	-Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо -Гэрээний хэрэгжилтийн хувь	2023 оны гэрээт байгууллагын гэрээг дүгнэж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна.	I улирал	Хэлтсийн дарг Д.Алтантуяа, Мэргэжилтэн Б.Амаржаргал
3.1.2	2024 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Өрхийн ЭМТ-3, Сумын ЭМТ-19, Эмийн сан-35	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	I-II улирал	Хэлтсийн дарг Д.Алтантуяа, Мэргэжилтэн Б.Амаржаргал
3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Лавлагаа шатлалын гэрээт 5 байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан.	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	II-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.							
3.2.1	БГТ-3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	-	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, Нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн	ЭМБ-ын тоо-88, Хянасан түүврийн тоо-7483 Эргэн мэдээлэл өгсөн ЭМБ-ын тоо-22 Зөвлөмж өгсөн ЭМБ-ын тоо 23	Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
3.2.2	БСТ-3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	-	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2023 онд 3 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	5 Эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	II-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.	-	Хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлага, актын тоо	2023 онд улсын байцаагчийн 66 зөвлөмж, 13 акт, 6 албан шаардлагыг хүргүүлсэн	Шаардлагатай тохиолдолд улсын байцаагчийн зөвлөмж, албан шаардлага, актыг хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллаж тайлагнасан байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
3.2.4	Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.2.3, БГТ-3.2.2 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.	-	-Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо -Хяналт шалгалтын тайлан	2023 онд 4 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт, шалгалт хийж зөвлөмж өгсөн.	Газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	II, IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид

**Зорилго 4.** Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
4.1.1	ЗГҮАХ-2.1.9, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.3 Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. -Тайлан	-	Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн дарг Д.Алтантуяа
4.1.2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.	-	Хамрагдсан сургалтын тоо	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалт - 12 ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалт- 16 Аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт - 8, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим сургалт - 6	ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг, мэдээлэл авсан байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
4.1.3	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо	Зохион байгуулсан арга хэмжээ - 4 Хамрагдсан хүн - 280	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
4.1.4	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг	-	Иргэд, даатгуулагчдад	ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж	ЭМДЕГ-ын фэйсбүүкийн хуудсанд	I-IV улирал	Мэргэжилтэн Б.Амаржаргал

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
	дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.		хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	хуудсанд байршуулсан мэдээллийг түгээсэн хувь- 80%, ЭМДХ-ээс бэлтгэсэн контентын тоо – 5 Хандалтын тоо - 2300	байршуулсан мэдээллийг 90 хувиас дээш байршуулж, ЭМДХ-ээс 10 контент бэлтгэж, хандалтын тоог 2500-д хүргэсэн байна.		
4.1.5	БГТ 4.1.8 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	Судалгаанд нийт 150 иргэн-даатгуулагч, 22 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан	Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	II улирал	Мэргэжилтэн Б.Амаржаргал
4.1.6	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15 Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.	-	Албан бичиг, санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Албан бичиг 8, өргөдөл 3, санал, хүсэлт 344 ирж, 100 хувь шийдвэрлэсэн.	Албан бичиг, санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг 100 хувь хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн бүх албан хаагчид
4.1.7	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.		Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Хэлтсийн мэргэжилтэний гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	I-IV улирал	Хэлтсийн дарг Д.Алтантуяа

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах албан хаагч
4.1.8	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө.	-	Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо	2023 онд 26 боть архивын нэгж үүсгэсэн.	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна	I-IV улирал	Мэргэжилтэн Ч.Мягмарсүрэн
4.1.9	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана.	-	Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь.	Хугацаанд тайлагнасан нь	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга Д.Алтантуяа
4.1.10	Хэлтсийн албан хаагчдийн төрийн албан хаагчийн хувийн хэргийг хэлтэс дээрээ журмын дагуу бүрдүүлж, баяжуулна.	-	Журмын дагуу бүрдүүлж, баяжуулсан албан хаагчдын хувийн хэрэг	-	Хэлтсийн бүх албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж, баяжуулсан байна.	I-IV улирал	Хэлтсийн дарга Д.Алтантуяа

-ooOoo-

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024.11.25

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1.2.1	БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээн ий мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	-	Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын 2023 онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр гүйцэтгэсэн тусламж үйлчилгээнд дүн шинжилгээ хийж, 2024 оны 5 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулагдсан аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн дээр Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс дараах чиглэлээр мэдээлэл хийсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- 2023 онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр гүйцэтгэсэн тусламж үйлчилгээний үзүүлэлт, цаашид анхаарах асуудал</li> <li>- Хөнгөлөлттэй эмийн жор бичихэд гаргаж байгаа алдаа, анхаарах асуудал</li> <li>- Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үзүүлж буй тусламж үйлчилгээний талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн, анхаарах асуудал</li> <li>- Зөрчлөөс урьдчилан сэргийлэх</li> <li>- Харьяа нутаг дэвсгэрийн малчдыг</li> </ul>	100

					<p>эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх</p> <p>- Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үзүүлж буй тусламж үйлчилгээ болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл өгч, санал хүсэлтийг сонсож, хариулт өглөө.</p> <p>Гэрээт эмийн сангуудын эрхлэгч нарт 2024 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр сургалт хийж, 2023 онд даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн үйлчилгээний үзүүлэлт, цаашид анхаарах асуудал, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээ үзүүлэхэд эмийн сангуудын эрх, үүргийн талаар мэдээлэл өгч, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж өгсөн.</p> <p>Нэгдсэн эмнэлгийн "Амбулаторийн хяналтын үзлэгийн гүйцэтгэлийн нэхэмжлэл"-д дүн шинжилгээ хийж, 07/169 дугаартай албан бичгээр "Амбулаторийн хяналтын үзлэгийн чанар, үр дүнг сайжруулах, хяналтын үзлэгийг зөв нэхэмжлэх" зөвлөмжийг өгсөн. Нэгдсэн эмнэлэг амбулаторийн хяналтын бүртгэлд бүртгэгдээгүй, байнгын хяналт шаардлагагүй, нэг удаагийн шинжтэй хяналт болон В, С вирусийн илрүүлэг шинжилгээг амбулаторийн хяналтын үзлэгээр нэхэмжилсэн тохиолдлууд байсан.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын сэргээн засах тусламж үйлчилгээнд дүн шинжилгээ хийхэд тухайн өвчнийг сэргээн засахад тохироогүй, ач холбогдол, үр дүн багатай тусламж үйлчилгээнүүдийг ихэвчлэн хийж, сэргээн засах тусламжийн гүйцэтгэлийг үр дүнгүй нэмэгдүүлж байна. Үүнтэй холбоотой</p>
--	--	--	--	--	--

						аймгийн Эрүүл мэндийн газарт анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжийг сайжруулах тухай 07/131 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Мөн сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах тухай Улсын ахлах байцаагчийн 10-14-07-001/14 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн.	
1.2.2	БГТ 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.	-	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	-	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Хугацаа болоогүй. Статистик мэдээллийн эмхэтгэл гарахаар эрүүл мэндийн байгууллага, иргэдэд түгээн сурталчлахаар хүлээгдэж байна.	-
1.2.3	"Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Журмыг хэрэгжүүлсэн байна.	Бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 6 дугаар тогтоолын сургалтуудад аймгийн Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг бүрэн хамруулж, тогтоолын талаар мэдлэгийг дээшлүүлсэн. Тогтоолуудыг бүх гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 07/109 дугаартай албан бичгээр хүргүүлж, эмч мэргэжилтнүүддээ танилцуулж, тусламж үйлчилгээндээ хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдсэн. Шинэчлэгдсэн тогтоолыг олон нийтэд сурталчлах зорилгоор Олон нийттэй харилцах хэлтсээс бэлтгэн ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд оруулсан мэдээллийг тухай бүр нь Архангай аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн фэйсбүүк пэйж хуудсанд байршуулж, иргэдэд мэдээлэл түгээсэн.	100

						<p>Тогтоолын өөрчлөлтийн талаар бүх эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнуудын зөвлөгөөн дээр мэдээлэл хийсэн.</p> <p>ЭМДҮЗ-ийн 2024 оны 6 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 14 дүгээр тогтоолыг бүх эрүүл мэндийн байгууллагуудад 07/109 дугаартай албан бичгээр хүргүүлж, хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдсэн. Мөн аймгийн ЭМГ-аас зохион байгуулсан "Шүд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад эмч, эмнэлгийн удирдлагын оролцоо, хамтын ажиллагаа" хэлэлцүүлэгт ЭМДҮЗ-ийн 2024 оны 14 дүгээр тогтоолд шүдний тусламж үйлчилгээний санхүүжилтийн талаар орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулж, мэдээлэл хийсэн.</p> <p>Тогтоолын хэрэгжилтэд сар бүр хяналт хийж, эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг утсаар, цахимаар, албан бичгээр өгч ажиллаж байна.</p>	
1.2.4	<p>ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.</p>	-	<p>Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо</p>	<p>ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна.</p>	<p>Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.</p>	<p>ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн "Төлбөрийн хэмжээ, арга хэмжээ, журам шинэчлэн батлах тухай" 5 дугаар тогтоолын талаар Бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан сургалтад бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг бүрэн хамруулж, тогтоолын шинэчлэлийн талаар мэдлэгийг дээшлүүлсэн.</p> <p>Тогтоолыг бүх гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад 07/109 дугаартай албан бичгээр албан бичгээр хүргүүлж, эмч мэргэжилтнүүддээ танилцуулж, тусламж үйлчилгээндээ хэрэгжүүлж ажиллахыг</p>	100

						<p>мэдэгдсэн.</p> <p>Тогтоолын өөрчлөлтийн талаар эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнуудын зөвлөгөөн дээр бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт мэдээлэл хийсэн.</p> <p>Тогтоолын хэрэгжилтэд сар бүр хяналт хийж, эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг утсаар, цахимаар, албан бичгээр өгч ажиллаж байна.</p>	
1.2.5	<p>Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.</p>	-	<p>Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо</p>	<p>Санхүүжүүлсэн мөнгөн дүн – 408,860,000 Хамрагдсан даатгуулагчийн тоо- 3486</p>	<p>Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.</p>	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэг нийт 1848 хүнд эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийж, нэхэмжилснийг хянаж, 280,215,000 төгрөгний санхүүжилт олгохоор баталгаажуулж, Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Ар Тооромт хувийн хэвшлийн эмнэлэг эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийх гэрээ байгуулж, нийт 753 хүнд эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийж нэхэмжилснийг хянаж, 122,788,000 төгрөгний санхүүжилт олгохоор баталгаажуулж, Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Тана Арцат хувийн хэвшлийн эмнэлэг эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийх гэрээ байгуулж, нийт 109 хүнд эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийж нэхэмжилснийг хянаж, 19,640,000 төгрөгний санхүүжилт олгохоор баталгаажуулж, Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.</p>	100
1.2.6	<p>ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого</p>	-	<p>Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо</p>	-	<p>Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.</p>	<p>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сэргээн засах тусламж үйлчилгээнд үнэлгээ хийж, үнэлгээний дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг 2024 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 12/43 тоот дотоод бичгээр Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.</p> <p>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүд сэргээн засах тусламж</p>	80

	<p>төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.</p>					<p>үйлчилгээний талаар мэдлэг хангалтгүй, сэргээн засахад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, орчин хангалтгүй, ихэвчлэн 2 төрлийн физик эмчилгээний аппаратаар тусламж үзүүлдэг, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал эмчилгээ хийдэггүй, физик эмчилгээний аппаратуудын баталгаажуулалт хийгдээгүй, бие махбодод үйлчилгээ үзүүлэх идэвх хэвийн байгаа эсэх нь тодорхойгүй байна. Үүнтэй холбоотой тухайн өвчнийг сэргээн засахад тохироогүй, ач холбогдол, үр дүн багатай тусламж үйлчилгээнүүдийг хийж, сэргээн засах тусламжийн гүйцэтгэлийг үр дүнгүй нэмэгдүүлж байна.</p>
--	---------------------------------------	--	--	--	--	--

**Зорилт 1.4. "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд:**

1.4.1	<p>Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.1.3, БГТ-1.4.3 Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.</p>	-	Хүргүүлсэн саналын тоо	12, 07 дугаар тогтоолын төсөлд нийт 6 санал хүргүүлсэн.	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	<p>Дараах тогтоол, журмын төсөлд санал хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2024 оны 12/10 дугаартай дотоод бичгээр "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолын төсөлд яаралтай тусламж, түргэн тусламж дээр нийт 2 санал,</li> <li>- 12/11 дугаартай дотоод бичгээр 3 ЭМБ-аас ирүүлсэн санал,</li> <li>- 12/12 дугаартай дотоод бичгээр А/611 дүгээр тушаалын шинэчилсэн хувилбарт 5 санал,</li> <li>- 12/14 дугаартай дотоод бичгээр "Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, холбогдох журмыг шинэчлэн батлах тухай" тогтоолын төсөлд 6 санал,</li> <li>- 12/32 дугаартай дотоод албан бичгээр "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээ болон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо,</li> </ul>
-------	---	---	------------------------	---	--	--

						<p>шинжилгээний нэхэмжлэлийн хяналтын шинэчлэн боловсруулсан шалгуур төсөл" –д 28 санал</p> <ul style="list-style-type: none"> <li>- 12/45 дугаартай дотоод бичгээр "Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх төлбөрийн арга, журмын төсөл"-д 13 санал</li> <li>- 12/52 дугаартай дотоод бичгээр 2024 оны 6 дугаар тогтоолын шинэчлэн боловсруулж байгаа төсөлд 6 санал, 5 дугаар тогтоолын шинэчлэн боловсруулж байгаа төсөлд 2 санал</li> <li>- 12/47 дугаартай дотоод бичгээр Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэх хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын төсөлд 2 санал хүргүүлсэн.</li> </ul>	
1.4.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо -Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	2023 онд аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Сум дундын иргэний хэргийн шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудтай хамтран ажилласан. Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн -	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	<p>Прокурорын байгууллага Цагдаагийн газартай хамтран ажиллаж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.1.1-д заасны дагуу гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад нөхөн төлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Цагдаагийн газарт гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирч, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж авсан 86 иргэний лавлагааг гаргаж өгсөн.</p> <p>Прокурорын газарт 2022 онд гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирч, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж авсан 21 иргэний мэдээллийг нөхөн гаргаж өгсөн.</p>	100

				6800000		Цагдаагийн газарт нэхэмжлэгчийн мэдүүлэг 72 удаа өгсөн. Архангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 48 иргэнтэй холбоотой 89,048,899 төгрөгний нэхэмжлэл гаргаж, 56,390,251 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд буцаан төлүүлээд байна.	
<b>Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.</b>							
<b>Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ.</b>							
2.1.1	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2023 онд 44,8 %	2024 онд 60 хувиас дээш хамруулна.	Малчдыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 12/04 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулах 2024 оны гэрээнд өөрөө шимтгэлээ хариуцан төлдөг малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах заалтыг оруулах тухай албан бичгийг хүргүүлж, гэрээнд тусгуулсан. Эхний 4 сарын байдлаар сум бүрийн малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь болон даатгалд хамрагдалтыг эрчимжүүлэх тухай албан бичгийг сумын ЭМТ-үүдэд 07/107 тоот албан бичгээр хүргүүлсэн. Сумдын Засаг дарга нарт "Малчдыг эрүүл мэндийн албан журмын даатгалд хамрагдалтыг эрчимжүүлэх тухай" албан бичиг хүргүүлэх төслийг боловсруулж, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлж, аймгийн ЗДТГ-ын албан бичгээр сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. 2024 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар Мэдээллийн технологийн хэлтсээс авсан мэдээгээр 5858 малчин ЭМДаатгалд хамрагдаж, хамрагдалтын хувь 46,5 хувьтай байна.	80
		-	Оюутны	2023 онд 16	2024 онд 30-аас	Оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд	100

		эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	%	дээш хамруулна	хувь	хамрагдалтыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран аймгийн бүх дээд сургууль, коллеж, МСҮТ-үүдийн удирдлагуудтай 4 дүгээр сарын 26-ны өдөр уулзалт хийж, мэдээлэл өгсөн. Орон нутгийн бүх их дээд сургууль, коллеж, МСҮТ-үүдийн захирал нарт 2024 оны 10 сарын 14-ны өдрийн 07/181 дугаартай албан бичгээр "Оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах тухай" албан бичгийг хүргүүлж, ЭМДаатгалын шимтгэл төлөлтийн хэмжээ, и-баримт болон и-монголиа аппликейшнээр шимтгэлээ хялбар төлөх боломж, эрт илрүүлэг үзлэгийн талаар сурталчилгааны 4 төрлийн постерыг хүргүүлж, оюутнуудад мэдээлэл өгсөн. МУБИС-ийн харъяа Багшийн сургуулийн 100 гаруй оюутанд "Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян"-ы хүрээнд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, шимтгэл төлөлт, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн талаар сургалт хийсэн. 2024 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар Мэдээллийн технологийн хэлтсээс авсан мэдээгээр 528 оюутан ЭМДаатгалд хамрагдаж, хамрагдалтын хувь 71 хувьтай байна.	
		Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2023 онд 78,8 хувь	2024 онд дээш хамруулна.	80-аас хувь	Аймгийн төвийн нийтийн худалдааны төвүүдээр явж, 70 гаруй хувиараа худалдаа эрхлэгч иргэдэд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, шимтгэл төлөлтийн хэмжээ, и-баримт, и-монголиа аппликейшнээр шимтгэлээ хялбар төлөх арга зэрэг зөвлөгөө, мэдээллийг өгсөн. 11 дүгээр сарын 25-ны байдлаар Мэдээллийн технологийн хэлтсээс авсан мэдээгээр тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 3018 иргэн ЭМДаатгалд хамрагдаж,	100

						хамрагдалтын хувь 76,5 хувьтай байна.	
		-	Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	2023 онд 104%	2024 онд шимтгэл төлөлт 98 хувиас доошгүй байна.	Аймгийн Нийгмийн даатгалын газрын эхний 3 дугаар улирлын тайлангаар нийт 745 байгууллага, аж ахуйн нэгжийн 9903 ажилтан эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, хамрагдалт 103 хувьтай байна.	100
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	-	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, тайлан мэдээг нэгтгэн 4 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 4 удаа хүргүүлсэн байна.	Сангийн зарлагын 2023 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн, гэрээт 64 байгууллагатай тооцоо нийлсэн актын хамт Санхүү бүртгэлийн хэлтэст 2024 оны 1 дүгээр сарын 10-нд хугацаанд нь хүргүүлсэн. 2024 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн 64 байгууллагатай тооцоо нийлсэн актын хамт Санхүү бүртгэлийн хэлтэст 2024 оны 8 дугаар сарын 05 -нд хугацаанд нь хүргүүлсэн. 2024 оны эхний 1 дүгээр улирлын сангийн зарлагын тайланг 4 сарын 05-ны өдөр, эхний хагас жилийн тайланг 8 дугаар сарын 05-ны өдөр, 3 дугаар улирлын тайланг 10 дугаар сарын 15-ны өдөр Санхүү бүртгэлийн хэлтэст хугацаанд нь бүрэн, зөв гаргаж хүргүүлсэн. Нийт давхардсан тоогоор 231,650 иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээнд 21,051,764,031 төгрөгний санхүүжилтийг ЭМДСангаас олгохоор Санхүү бүртгэлийн хэлтэст нэхэмжлэл, баталгаажуулах хуудсыг хүргүүлсэн. Үүнд: Анхан шатны 22 байгууллага нийт 48972 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж, 5,577,936,023 мян/төгрөгний санхүүжилт, Нэгдсэн эмнэлэг нийт 11653 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж, 12,134,224,116 мян/төгрөгний санхүүжилт, хувийн хэвшлийн 4 эмнэлэг нийт 9347 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж, 1,359,748,963 мян/төгрөгний санхүүжилт, 1 сувилалд 464 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж,	100

						142,045,581 мян/төгрөгийн санхүүжилт, 37 эмийн сан 61214 иргэнд хөнгөлөлттэй эмээр үйлчилж, 1,837,809,348 мян/төгрөгний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон.	
2.1.3	Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	-	-Өглөг, авлагын тоо хэмжээ -Тайлан	2023 онд 66 ЭМБ-ын 1,025,694,000 төгрөгийн өглөг, 2 ЭМБ-ын 8910345 төгрөгийн авлагын тайланг гаргаж, ЭМДЕГ-г хүргүүлсэн.	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.	Тунгалаг тамир хувийн хэвшлийн эмнэлэгт 2022 онд урьдчилгаа төлбөр хэлбэрээр өгч үүссэн 6,722,925 төгрөгийн авлагыг барагдуулсан. 2023 онд 66 эрүүл мэндийн байгууллагад ЭМДЕГ-аас өгөх 1,025,694,001 төгрөгийн өглөгийг барагдуулсан. 2024 онд эхний 3 дугаар улирлын байдлаар 61 эрүүл мэндийн байгууллагад 3,214,556,805 төгрөгийн өглөг шинээр үүссэн. Шинээр авлага үүсээгүй.	100
2.1.4	ЭМДТХ-9.1.9 "Алсын хараа 2050", МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7 Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж тайлагнана.	-	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2023 оны биелэлт 80 хувь	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь 90-ээс доошгүй хувь хэрэгжүүлж ажилласан байна.	Ажил олгогч болон даатгуулагчийн төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого эхний 3 дугаар улирлын байдлаар 5,035,179,525 төгрөг төлөвлөгдсөнөөс 5,201,126,540 төгрөг төлөгдөж, 103,3 хувьтай биелсэн.	100
<b>Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна.</b>							
<b>Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.</b>							
3.1.1	БСТ-3.1.2, БГТ-3.1.1 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, сум, өрхийн эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	-Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо -Гэрээний хэрэгжилтийн хувь	2023 оны гэрээт байгууллагын гэрээг дүгнэж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн	Гэрээт 36 эмийн сангийн гэрээг дүгнэж, 22 эмийн сан 90 хувиас дээш, 12 эмийн сан 80-89,9 хувь, 1 эмийн сан 78 хувиар үнэлэгдэж, 1 эмийн сан гэрээгээ дүгнүүлээгүй. Гэрээний үнэлгээг үндэслэн 1 эмийн сангийн гэрээг цуцалж, 1 эмийн санд албан шаардлага хүргүүлсэн. Гэрээний үнэлгээний тайлан, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.	100

					байна.	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 4 хувийн хэвшлийн эмнэлэг, 1 сувиллын гэрээг үнэлж, гэрээний үнэлгээний тайланг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн. Үнэлгээгээр бүх лавлагаа шатлалын ЭМБ, сувилал 90-ээс дээш хувь үнэлэгдсэн.</p> <p>Бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2023 оны гэрээг дүгнэж, гэрээний үнэлгээг баталгаажуулж, Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн. Үнэлгээгээр 2 сумын эрүүл мэндийн төв 69,9 –өөс доош хувь буюу хангалтгүй, 17 сумын эрүүл мэндийн төв 70- 89,9 хувь буюу хангалттай, 2 өрхийн эрүүл мэндийн төв 90-ээс дээш хувь буюу маш сайн, 1 өрхийн эрүүл мэндийн төв 88,8 хувь буюу хангалттай үнэлэгдсэн.</p> <p>Хангалтгүй үнэлэгдсэн Цэнхэр сумын эрүүл мэндийн төв, Хашаат сумын эрүүл мэндийн төвүүдэд улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.</p>	
3.1.2	2024 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Өрхийн ЭМТ-3, Сумын ЭМТ-19, Эмийн сан-35	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	<p>2024 онд нийт 37 эмийн сантай "Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх" гэрээ байгуулах үйл ажиллагааг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж, гэрээг баталгаажуулан Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.</p> <p>3 өрхийн ЭМТ, 19 сумын ЭМТ-тэй "Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах" гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулж, гэрээг баталгаажуулан Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.</p> <p>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хугацаа дуусаагүй байгаа.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй өдрийн сэргээн засах тусламж үйлчилгээ хийх, Ар Тооромт,</p>	100

						Тана Арцат хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх нэмэлт гэрээнүүдийг баталгаажуулж, Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн. ЭМДҮЗ-ийн "Төлбөрийн хэмжээ, арга хэмжээ, журам шинэчлэн батлах тухай" 5 дугаар тогтоол шинэчлэн батлагдсантай холбогдуулан сум, өрхийн ЭМТ-үүдтэй байгуулах "Нэмэлт гэрээ"-г баталгаажуулж, Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.	
3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Лавлагаа шатлалын гэрээт 5 байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан.	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	Чанар, төлбөрийн хяналтын журамд одоогоор өөрчлөлт орж батлагдаагүй байна.	-
<b>Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.</b>							
3.2.1	БГТ-3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	-	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, Нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн	ЭМБ-ын тоо-88, Хянасан түүврийн тоо-7483 Эргэн мэдээлэл өгсөн ЭМБ-ын тоо-22 Зөвлөмж өгсөн ЭМБ-ын тоо 23	Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын нийт 12,248 түүвэрлэгдсэн тусламж үйлчилгээнд олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурын дагуу хугацаанд нь хяналтыг хийж, шалгуур хангаагүй 2086 тусламж үйлчилгээний 635,239,565 төгрөгний хасалтыг хийсэн. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг хянаж, шалгуур хангаагүй 2235 тусламж үйлчилгээний 398,523,478 төгрөгний хасалтыг хийсэн.	100
3.2.2	БСТ-3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн	-	Зөвлөн туслах үйлчилгээ	2023 онд 3 ЭМБ-д зөвлөн	5 байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн	Бүх АШЭМБ-уудын эмч, мэргэжилтнүүдэд ЭМДЕГ-ын цахим программд тусламж үйлчилгээг бүрэн, зөв бүртгэж, мэдээлэх	90

	туслах үйлчилгээ үзүүлнэ.		үзүүлсэн байгууллагын тоо	туслах үйлчилгээ үзүүлсэн.	байна.	<p>цахим сургалтыг Цэнхэр сумын эмч Нямжанцангаар (сум, өрхийн ЭМТ-үүдийг төлөөлөн ЭМДЕГ дээр цахим программын сургалтад суусан эмч) зохион байгуулсан. Бүх өрхийн эрүүл мэндийн төвд газар дээр нь очиж ажиллан 1 иргэнээр тооцсон санхүүжилтээр үзүүлж буй тусламж үйлчилгээ болон ЭМДаатгалаар хөнгөлөлттэй үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, үр дүн, хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөмж өгч, санал хүсэлтийг сонсож, хариулт өгсөн.</p> <p>Яаралтай тусламж үйлчилгээг сайжруулах, гүйцэтгэлийг зөв нэхэмжлэх чиглэлээр Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт, Уламжлалтын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг сайжруулах, зөв нэхэмжлэх чиглэлээр Нэгдсэн эмнэлгийн Уламжлалт эмчилгээний тасагт зөвлөгөө өгсөн.</p> <p>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр Тана Арцат хувийн хэвшлийн эмнэлэг, Ар Тооромт хувийн хэвшлийн эмнэлгүүдэд зөвлөгөө өгсөн.</p> <p>ЭМДаатгалын хөнгөлөлттэй эмийн жор бичихэд анхаарах асуудлаар Нэгдсэн эмнэлэгт 12/20 дугаартай албан бичгээр, сум, өрхийн ЭМТ-үүдэд 12/19 дугаартай албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Сумын эрүүл мэндийн төвүүдэд үзүүлж буй яаралтай тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн чанар, үр дүнг сайжруулах, нэхэмжлэлийг ангилал ахиулахгүй зөв нэхэмжлэх чиглэлээр ЭМДҮЗ-ийн 2024 оны 6 дугаар тогтоолын яаралтай тусламжийн гүйцэтгэлийг нэхэмжлэх зохицуулалтын хэсгийг сургалтын хичээл болгон бэлтгэж сумын ЭМТ-үүдэд хүргүүлсэн.</p> <p>Гэрээт бүх лавлагаа шатлал, анхан шатны</p>
--	---------------------------	--	---------------------------	----------------------------	--------	--

						<p>эрүүл мэндийн байгууллагуудад "Өвчний түүх, яаралтай тусламж, түргэн тусламжийн анхан шатны маягтуудыг бүрэн, үнэн, зөв хөтлөх зөвлөмж"-ийг 07/43 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Сумын ЭМТ-үүдэд яаралтай тусламжийн чанарыг сайжруулах, гүйцэтгэлийг зөв нэхэмжлэх зөвлөмжийг 07/179 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Бүх сум, өрхийн ЭМТ-үүдэд нэг иргэнээр тооцсон санхүүжилтээр гүйцэтгэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг сайжруулах зөвлөмжийг 07/207 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Гэрээт бүх ЭМБ-уудад эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээний гүйцэтгэл, нэхэмжлэл, санхүүжилт, программтай холбоотой үүссэн асуултуудад тухай бүр нь хариулт, зөвлөгөө, мэдээллүүдийг өгч, ямар нэгэн алдаа, дутагдал, гомдол гараагүй.</p> <p>ЭМДЕГ-ын Тамгын газарт 12/39 дугаартай дотоод бичгээр "Сумын эрүүл мэндийн төв, эмийн сангуудад газар дээр нь очиж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх удирдамж"-ийг батлуулахаар хүргэсэн боловч батлагдаагүй тул сумын ЭМТ, сумын эмийн сангуудад газар дээр нь очиж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээгүй.</p>	
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.	-	Хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлага, актын тоо	2023 онд улсын байцаагчийн 66 зөвлөмж, 13 акт, 6 албан шаардлагыг хүргүүлсэн	Шаардлагатай тохиолдолд улсын байцаагчийн зөвлөмж, албан шаардлага, актыг хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллаж тайлагнасан байна.	<p>Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн нэхэмжлэлийг хянаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тухай улсын байцаагчийн дараах зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нэгдсэн эмнэлэг, бүх гэрээт хувийн хэвшлийн эмнэлгүүдэд "ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан Хэвтэх бичиг</li> <li>- А6 маяг"-ийн хөтлөлтийг</li> </ul>	100

						<p>сайжруулах, бүрэн үнэн зөв хөтлөх тухай улсын байцаагчийн зөвлөмж</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ар Булгантамир эмийн санд зөрчил арилгуулах тухай Улсын байцаагчийн албан шаардлага</li> <li>- 9 сумын эрүүл мэндийн төвд "Хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээ, яаралтай тусламж, түргэн тусламжийн үйл ажиллагааг сайжруулах" Улсын байцаагчийн зөвлөмж</li> <li>- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт "Сэргээн засах тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах тухай" Улсын байцаагчийн зөвлөмж</li> <li>- Сумын эрүүл мэндийн төвүүдэд "Яаралтай тусламжийн чанар, үр дүнг сайжруулах, код ахиулж нэхэмжлэхгүй байх" Улсын ахлах байцаагчийн зөвлөмж</li> <li>- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт "Анхан шатны маягтыг бодит цагийн горимоор бүрэн, үнэн, зөв хөтлөх тухай" Улсын ахлах байцаагчийн зөвлөмж</li> <li>- Тариат сумын ЭМТ-д "Шүдний тусламж үйлчилгээг бодит цагийн горимоор нэхэмжлэх, 7-аас дээш насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг ЭМДаатгалд нэхэмжлэхгүй байх, хэвтүүлэн эмчлэх тусламжийг мэс заслаар нэхэмжлэхгүй байх тухай" Улсын ахлах байцаагчийн зөвлөмж</li> <li>- Сум, өрхийн ЭМТ-үүдэд "Сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах тухай" Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг тус тус хүргүүлж, хэрэгжилтийг</li> </ul>
--	--	--	--	--	--	--

						<p>хангуулан ажиллаж байна.</p> <p>Мөн хэлтсийн албан тоотоор зөвлөмжүүдийг хүргүүлсэн. Үүнд: Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 12/20, 12/21, 07/43 дугаартай албан бичгээр, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 12/19, 07/43, 07/63 07/65, 07/83, 07/179 дугаартай албан бичгээр, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 07/43 дугаартай албан бичгээр зөвлөмж, анхааруулгуудыг хүргүүлж, хэрэгжилтийн хангуулан ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй эм олгох үйл ажиллагаанд 4 эмийн санд газар дээрх хяналт хийж, 1 эмийн санд улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Улаанбаатар хотын эмнэлгүүдийн 1 дүгээр сарын тусламж үйлчилгээний түүвэрт хийсэн хяналтын хасагдлын шалтгааныг 22/07 тоот дотоод албан бичгээр Нэхэмжлэлийн хяналтын хэлтэст хүргүүлсэн.</p>	
3.2.4	<p>Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.2.3, БГТ-3.2.2</p> <p>Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.</p>	-	<p>-Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо</p> <p>-Хяналт шалгалтын тайлан</p>	<p>2023 онд 4 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт, шалгалт хийж зөвлөмж өгсөн.</p>	<p>Газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.</p>	<p>Иргэн Д.Цэнд-Аюуш аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэх хугацаанд гаднаас эм, тариа авахуулсан гэсэн өргөдлийн дагуу Нэгдсэн эмнэлэг дээр газар дээрх хяналт хийж, аймгийн Прокурорын газарт хяналтын тайлан, дүгнэлтийг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.</p> <p>Нэгдсэн эмнэлэгт тусламж үйлчилгээ авах хугацаанд эм тариа, эмнэлгийн хэрэгсэл авахуулсан болон тусламж үйлчилгээ аваагүй гэсэн 3 иргэний мессеж үйлчилгээний дагуу иргэн бүртэй холбогдож мэдээлэл авч, гаднаас эм тариа авахуулсан 1 иргэний өвчний түүхийг Нэгдсэн эмнэлгээс авч хянан, эм тарианы мөнгийг буцаан олгох тухай 07/146 дугаартай албан бичгийг Нэгдсэн эмнэлгийн даргад хүргүүлж, мөнгийг буцаан олгосон. Бусад 2 иргэн нь мессеж үйлчилгээнд өөрсдөө буруу</p>	100

					<p>мэдээлэл өгсөн гэдгээ хэлсэн.</p> <p>Худалдан авалт гэрээлэлтийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу дараах хяналтуудыг газар дээр нь болон цахимаар хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нэгдсэн эмнэлэг дээр Сэргээн засах амбулаторийн тусламж, сэргээн засахын өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжийг 2 дугаар сарын 29-ны өдөр газар дээр нь</li> <li>- Сумын эрүүл мэндийн төвүүдийн шүд, амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжийг 2 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд цахимаар</li> <li>- Ар Тооромт эмнэлэгт урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх чадамжийг 4 дүгээр сарын 30-ны өдөр газар дээр нь,</li> <li>- Тана Арцат эмнэлэг дээр урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ хийх чадамжийг 8 дугаар сарын 06-ны өдөр газар дээр нь</li> <li>- Сумын эрүүл мэндийн төвүүдийн уламжлалт, шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжийг 6 дугаар сарын 10-14-ны өдрүүдэд цахимаар</li> <li>- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах лабораторийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадамжийг 6 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд сумын ЭМТ-үүдийг цахимаар, өрхийн ЭМТ-үүдийг газар дээр нь тус тус хянаж, хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлтийг .Худалдан авалт гэрээлэлтийн газарт хугацаанд нь</li> </ul>
--	--	--	--	--	--

						хүргүүлсэн.	
Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.							
Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.							
4.1.1	ЗГҮАХ-2.1.9, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.3 Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. -Тайлан	-	Орон нутгийн удирдлагатай хамтран арга авч хэрэгжүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын тамгын газраас Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн ажиллах нөхцлийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын тамгын газрын 2 дугаар байрны 3 давхарын 2 өрөөг ямар нэг түрээс, ус, цахилгааны зардалгүйгээр ашиглуулж, хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр хангаж байна. Орон нутгаас зохион байгуулж буй бүх сургалт, семинарын мэдээллийг аймгийн ЗДТГ-аас хэлтсийн мэйл хаягаар ирүүлж, сургалт, зөвлөгөөнд тухай бүр нь оролцуулж, мэдээллээр хангаж байна. Орон нутгийн төсвөөс төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутагт ажилласны нэмэгдлийг манай хэлтсийн албан хаагчдад олгохгүй байсан асуудлыг аймгийн Засаг даргад албан бичгээр хүсэлт өгч шийдвэрлүүлсэн.	90
4.1.2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.	-	Хамрагдсан сургалтын тоо	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалт – 12 ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалт-16 Аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт – 8,	ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг, мэдээлэл авсан байна.	ЭМДЕГ-аас зохион байгуулсан шинэчилсэн тогтоолуудын сургалт, 14 хоног тутам зохион байгуулагддаг "Мэдээллийн цаг"-ийн сургалт, "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал" сургалтуудад хэлтсийн мэргэжилтнүүд бүрэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн.	100
4.1.3	Салбарын хууль тогтоомж,	-	Зохион	Зохион	Сургалт,	Багшийн сургуулийн дотуур байрны 50 гаруй	90

	<p>тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.</p>		<p>байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо</p>	<p>байгуулсан арга хэмжээ – 4 Хамрагдсан хүн - 280</p>	<p>сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.</p>	<p>оюутанд и-баримт аппликейшн болон и-монголиа аппликейшн ашиглан ЭМДаатгалын шимтгэл төлөлтөө шалгах, шимтгэлээ төлөх талаар мэдээлэл өгсөн. ЭМД-ын ач холбогдол, и-баримт аппликэйшн, и-монголиа аппликэйшн ашиглан ЭМДаатгалаа хялбар төлөх арга, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдлын талаар иргэдэд сургалт, сурталчилгаа хийх хичээлийг шинэчлэн бэлтгэж сум, өрхийн ЭМТ-үүдэд хүргүүлж, иргэдэд ЭМДаатгалыг сурталчлан таниулах үйл ажиллагаанд ашиглаж байна. Нийтийн худалдааны төвд хувиараа худалдаа эрхлэгч иргэд болон үйлчлүүлэгч нийт 70 гаруй иргэнд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, и-баримт аппликейшн, и-монголиа аппликейшн ашиглан ЭМДаатгалын шимтгэл төлөлтөө шалгах, шимтгэлээ төлөх талаар мэдээлэл өгсөн. МУБИС-ийн харъяа Багшийн сургуулийн 100 гаруй оюутанд "Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян"-ы хүрээнд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, шимтгэл төлөлт, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн талаар сургалт хийсэн. ЭМДаатгалыг сурталчлах зорилгоор ЭМДЕГ-ын ОНХХ-ээс ирүүлсэн сурталчилгааны материалуудыг гэрээт 65 эрүүл мэндийн байгууллагад бүрэн хүргүүлж, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулсан.</p>	
4.1.4	<p>Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ,</p>	-	<p>Иргэд, даатгуулагч дад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо</p>	<p>ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд байршуулсан мэдээллийг түгээсэн хувь-</p>	<p>ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд байршуулсан мэдээллийг 90 хувиас дээш байршуулж, ЭМДХ-</p>	<p>Архангай аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс гэсэн фэйсбүүк групп болон пэйж хуудсыг тогтмол ажиллуулан, эрүүл мэндийн даатгалаар иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг</p>	100

	мэдээлэл хүргэнэ.			80%, ЭМДХ-ээс бэлтгэсэн контентын тоо – 5 Хандалтын тоо -2300	ээс 10 контент бэлтгэж, хандалтын тоог 2500-д хүргэсэн байна.	сурталчлах үйл ажиллагааг тогтмол хийж, ЭМДЕГын фэйсбүүкийн пэйж хуудсанд байршуулсан мэдээллийг тухай бүр шэйрлэн нийт 700 гаруй мэдээлэл оруулж иргэдэд хүргэсэн. Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс өөрсдөө 12 контент бэлтгэж пэйж хуудсанд дээрээ байршуулсан. Пэйж хуудсанд давхардсан тоогоор 20000 орчим хүн хандаж мэдээлэл авсан. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн пэйж хуудсанд хэлтсийн байршлын хаяг, мэйл хаяг, утасны дугаарыг ил байрлуулсан. Хэлтсийн үүдний хэсэгт эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт, Е-баримт аппликэйшнээр эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөө хялбар төлөх заавар, ЭМДаатгалын шимтгэл төлөлтийн хэмжээг ил байршуулсан.	
4.1.5	БГТ 4.1.8 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	Судалгаанд нийт 150 иргэн-даатгуулагч, 22 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан	Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Гэрээт бүх эрүүл мэндийн байгууллагуудад 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 07/96 тоот "Сэтгэл ханамжийн судалгаа авах тухай" албан бичгийг хүргүүлж, 4 дүгээр сарын 25-аас 5 дугаар сарын 10-ны хооронд иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах үйл ажиллагааг google form-оор зохион байгуулж, нийт 474 иргэн оролцсон. Судалгаанд оролцогчдын 89 хувь нь ЭМДаатгалын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар ЭМДаатгалын байгууллагатай харилцсан байна. 85 хувь нь ЭМДаатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний талаар мэдэж байна. 77 хувь нь ЭМДаатгалыг албан журмын даатгал гэдгийг мэдэж байна. ЭМДаатгалын талаар 60 орчим хувь нь фэйсбүүкээс, 30 гаруй хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авч байна. 85 хувь нь шаардлагатай үедээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ЭМДаатгалаа ашиглан	100

						<p>авч чадаж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах үед гаднаас эм тариа, эмнэлгийн хэрэгсэл авахуулсан гэж 8 хувь нь хариулсан байна. Сэтгэл ханамжийн судалгааны дүнг зөвлөмж, анхаарах асуудлын хамт эрүүл мэндийн байгууллагуудад 07/106 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>ЭМДЕГ-ын Олон нийттэй харилцах хэлтсээс зохион байгуулж байгаа байгууллагын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамжийн судалгаанд гэрээт ЭМБ-уудыг оролцохыг 07/139 дугаартай албан бичгээр мэдэгдэж, нийт 138 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд судалгаанд оролцсон.</p>	
4.1.6	<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15</p> <p>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.</p>	-	<p>Албан бичиг, санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь</p>	<p>Албан бичиг 8, өргөдөл 3, санал, хүсэлт 344 ирж, 100 хувь шийдвэрлэсэн</p>	<p>Албан бичиг, санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг 100 хувь хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээнд Нэгдсэн эмнэлэг иргэнээс илүү төлбөр авсан гэж биеэр ирж өгсөн гомдлыг шийдвэрлэх талаар Нэгдсэн эмнэлгийн даргад 07/45 тоот албан бичгээр мэдэгдэж шийдвэрлүүлсэн.</p> <p>ХАГГ-аас манай хэлтэст шилжүүлсэн "Сувд сувилал эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээнд иргэнээс урьдчилан төлбөр авч тухай иргэнд буцааж өгөөгүй" гэсэн өргөдлийг Сувд сувилалд 07/78 тоот албан бичгээр мэдэгдэж, шийдвэрлүүлсэн.</p> <p>Аймгийн ЗДТГ-ын иргэд олон нийттэй харилцах 70331111 дугаарын утсанд 1 иргэнээс ирсэн ЭМДаатгалын шимтгэлийн илүү төлөлтийг буцааж олгохгүй байна гэсэн өргөдлийг ЭМДЕГ-ын Санхүү бүртгэлийн хэлтсээс тодруулан иргэнд хариуг утсаар мэдэгдсэн.</p> <p>Засгийн газрын олон нийттэй харилцах 11-11 дугаарын утсанд 1 иргэнээс Нэгдсэн эмнэлгийн амбулаторит битүүмж үүссэн гээд дараагийн эмчид үзүүлж чадахгүй байна гомдлын дагуу Нэгдсэн эмнэлгийн</p>	100

						<p>даргад 07/135 дугаартай албан бичгээр тус иргэний гомдлыг шийдвэрлэхийг мэдэгдэж, шийдвэрлүүлсэн.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгээс ирсэн 1, өрхийн эрүүл мэндийн төвөөс ирсэн 3, гэрээт эмийн сангаас ирсэн 1 нийт 5 гэрээт эрүүл мэндийн байгууллагаас ирсэн хүсэлтийг Бодлого төлөвлөлтийн газар, Тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газар, Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт шалгуулах, Е-баримт аппликейшнээр шимтгэл төлөх, шимтгэлийн илүү төлөлтийг буцаах болон шинэ төрсөн хүүхдийн овог, нэр оруулах, төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн ноогдуулалт хийлгүүлэх талаар утсаар, биеэр, цахимаар хандсан 765 иргэнд тухай бүр нь асуудлыг шийдвэрлэж, санал гомдол гараагүй.</p>	
4.1.7	<p>Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p>	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	<p>Хэлтсийн мэргэжилтэний гүйцэтгэл-ийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж, ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан</p>	<p>Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.</p>	<p>Хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан хэлтсийн албан хаагчдын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж, ажлын цаг баримтлалтад хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар ханган, хэлтсийн хэрэгжүүлэх чиг үүргийн үйл ажиллагааг тухай бүрт нь хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг 5 дугаар сарын 27-ны өдөр дүгнэж, мэргэжилтэн Ч.Мягмарсүрэн 93,9 хувь, мэргэжилтэн Б.Амаржаргал 95,3 хувь үнэлэгдсэн. Мэргэжилтэн Ч.Мягмарсүрэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 25-нд дүгнэж, 93,1 хувь үнэлэгдсэн. Мэргэжилтэн Б.Амаржаргал</p>	100	

						төрсний дараах амралттай байгаа.	
4.1.8	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө.	-	Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо	2023 онд 26 боть архивын нэгж үүсгэсэн.	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна	ЭМДЕГ-аас зохион байгуулсан "Баримт бичгийн стандарт, баримт бичиг зохион бүрдүүлэх аргазүй, анхаарах асуудал" сургалтад хэлтсийн бүр мэргэжилтнүүд оролцож, мэдлэгээ дээшлүүлсэн. Хэлтсийн албан бичиг хөтлөлтийг стандартын дагуу боловсруулж, файл хэлбэрээр болон цаасан хэлбэрээр хадгалж байна. 2023 оны баримтуудыг 34 боть, 2024 оны эхний 3 улирлын баримтуудыг 24 боть болгон архивын нэгж үүсгэн хадгалж байна. 2023 оны баримтуудыг Аудитад шалгуулсны дараа ЭМДЕГ-ын архивт хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж байна. 2024 оны эхний хагас жилийн албан бичгүүдийг PDF файл болгож, Тамгын газрын бичиг хэрэгт хүргүүлсэн.	100
4.1.9	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана.	-	Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь.	Хугацаанд нь тайлагнасан	Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна.	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, 10 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100
4.1.10	Хэлтсийн албан хаагчдийн төрийн албан хаагчийн хувийн хэргийг хэлтэс дээрээ журмын дагуу бүрдүүлж, баяжуулна.	-	Бүрдүүлж, баяжуулсан албан хаагчдын хувийн хэрэг	-	Хэлтсийн бүх албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж, баяжуулсан байна.	Хэлтсийн 3 албан хаагчийн төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж, Төрийн албаны зөвлөлөөс ирсэн шалгалтад шалгуулж, ямар нэгэн зөрчил илрээгүй.	100
<b>ХОЁР. МЭДЛЭГ, ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
2.1.1	Бусад байгууллага, төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, семинарт бүрэн хамрагдана.		Зохион байгуулагдсан сургалт, семинарт хамрагдана.	Сургалт, семинарт бүрэн хамрагдсан.	Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна.	Аймгийн ЗДТГ, Архивын тасаг, Төрийн албаны зөвлөл, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, ЭМЯ, Цахим хөгжлийн яам, аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн газар, Статистикийн хэлтэс,	100

					<p>Төрийн аудит, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан нийт 18 удаагийн сургалтад оролцсон.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 цахим сургалтад тогтмол сууж мэдлэгээ дээшлүүлж байна.</p> <p>Удирдлагын академиас орон нутагт зохион байгуулсан "Төрийн байгууллага, зохион байгууллалтын нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал" сэдэвт 2 өдрийн сертификаттай сургалтад хамрагдсан.</p> <p>"Зангиа академ"-ийн "Байгууллагын хөгжлийн хандлага, удирдлагын загварууд", "Ажил дээрх асуудал шийдвэрлэлт", "Ажилтны ёс зүй ба хариуцлага" онлайн хичээлүүдийг үзэж, мэдлэгээ дээшлүүлсэн.</p>
--	--	--	--	--	--

**Төлөвлөгөөг үнэлсэн:**  
 ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ,  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

**Төсвийн шууд захирагч**

(М.НАРМАНДАХ)  
 2024.12.16 (огноо)

**Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн**  
 ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ  
 ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

**Нэгжийн дарга**  
 (Б.ОЮУНЦЭЦЭГ)  
 2024.12.16 (огноо)

**Тайлагнасан:**  
 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
 ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

**Нэгжийн дарга**  
 (Д.АЛТАНТУЯА)  
 2024.12.25 (огноо)

